

## ИХ МОНГОЛ УЛС, СОЛОНГОС УЛСЫН ХАРИЛЦААНД ЕЛЮЙ ЧУЦАЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

*Н.Төмөр\**

Монгол, Солонгос хоёр улсын харилцаа нь тэр үеийн Монгол ба бусад орны харилцаанаас өвөрмөц шинжтэй байсан. 1211 онд Алтан улсын ноёрхолын дор байсан Елюй Люге тэргүүтэй хятан нар Алтан улсын эсрэг тэмцэл хийж, 1212 онд Монголын цэрэгтэй хамтран Алтан улсын эсрэг байлдаанд оролцохоор Чингис хаантай хэлэлцээр байгуулжээ.<sup>1</sup> Елюй Люге 1213 онд биеэ Ляо улсын ван хэмээн өргөмжилж, 1214 онд Алтан улсын Пусянь Ваньну жанжны тэргүүлсэн 400 мянган цэргийг бут цохиж, Ляодунгийн Сяньпин /одоогийн Ляонин мужийн Кайюань хот/ хэмээх газрыг эзлэн авч нийслэлээ болгосон боловч удалгүй 1215 онд Их Монгол улсад дагаар оржээ.<sup>2</sup> Гэвч Елюй Люге-гийн захиргаанд байсан Е Сы Бу зэрэг цэргийн жанжин нар Их Монгол улсад бууж өгөхөөс таггалзаж Чингис хааны илгээсэн элч нарыг алжээ. Ийнхүү Е Сы Бу тэргүүтэй хятан нар Их Монгол улс, Алтан улсын хоёр талын цэргийн хүчний шахалтаар Солонгос улсын нутагт арга буюу зугатан очжээ. Солонгос улсын нутагт цөмрөн орсон хятан нар Кандон /одоогийн Пхеньян хотоос зүүн тийш оршиж байсан/ хотыг эзлэн, тэндэхийн газар нутгийг булаан, хүн амыг түйвээж, нутгийн ард иргэдэд ихээхэн гай зовлон учруулж байлаа.<sup>3</sup> Солонгос улсын нутагт цөмрөн орсон хятан нарыг Их Монгол улс, Солонгос улстай хүч хамсан бут цохих болсон 1218 оноос Монгол, Солонгосын харилцаа анх эхэлжээ.<sup>4</sup> Монгол, Солонгосын хамтарсан цэргийн хүч хятан нарын дэгдээсэн самууныг богино хугацаанд амархан даржээ. Монголын цэргийн жанжин Хажин, Жала нар цэргээ авч буцахын өмнө Чингис хааны эрх олгосны дагуу Солонгосын талтай хэлэлцээ хийж Монгол, Солонгосын хооронд найрамдлын гэрээ байгуулж “хоёр улс үүрд ах дүү” байхаар тохиролцжээ.<sup>5</sup> Энэ гэрээний дагуу Солонгосын ван жил болгон Их Монгол улсад алба өргөн 15 хүнтэй элч зарж байхаар тогтжээ. Хоёр улс эвийн хэлэлцээр байгуулсны дараа элч төлөөлөгч харилцан илгээх, алба өргөх зэрэг хэлбэрээр харилцаж байв.<sup>6</sup> Гэвч 1225 онд Монголоос Солонгосод ирсэн элч буцах замдаа алагдсанаас болж хоёр улсын харилцаа тасарч, 1231 он хүртэл 6 жилийн хугацаанд Их Монгол улс, Солонгос улсын хооронд үндсэндээ ямар ч харилцаагүй, элч төлөөлөгчид ч солилцсонгүй билээ.

\*Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Өгэдэй хаан, хаан ширээнд өргөмжлөгдсөнөөс хойш 2 жилийн дараа буюу 1231 оны 8-р сард Салидай жанжнаар удирдуулсан монголын цэргийг, элч алсан хэргийг шүүлгэхээр Солонгос улс руу илгээж, олон хот, суурин газрыг нь эзлэн авч улмаар нийслэл Гэгэн хотыг /одоогийн Кэсон/ бүслэн авчээ.<sup>7</sup> Ийнхүү Монгол, Солонгос хоёр улсын харилцаа дайн байлдааны хэлбэрээр дахин сэргэжээ.

Их Монгол улсын Төв бичгийн яам /Засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яам/-ны тэргүүн сайд Елюй Чуцай хааны ордны хятад хэл дээрхи бичиг баримтыг хариуцдаг бичээч<sup>8</sup> болон тухайн үед Солонгос улсын төрийн бичиг<sup>9</sup> нь хятад бичиг байсан зэрэг учир шалтгаанаар Өгэдэй хааны үед Монгол, Солонгос хоёр улсын харилцааны асуудалд өөрийн биеэр оролцож, Монгол, Солонгосын харилцааг хөгжүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэсэн билээ.

Солонгос улсын төрд өндөр алба хашиж Солонгос, Монголын харилцаанд зохих үүрэг гүйцэтгэж байсан Ли Кюү Бу хэмээх түшмэл Солонгос улсын вангийн нэрийн өмнөөс Елюй Чуцайд хоёр удаа захидал илгээж Солонгос, Монголын харилцааг хэвийн болгон сайжруулахад тус хүргэхийг хүсчээ.<sup>10</sup> Елюй Чуцай болон тухайн үеийн Монгол, Солонгосын харилцааг судлахад чухал ач холбогдолтой эдгээр захидлуудыг Ли Кюү Бу “Зүүн улсын сайд Ли-гийн зохиолын эмхтгэл”-дээ оруулжээ.<sup>11</sup>

1231 онд Өгэдэй хааны цэрэг Солонгосын нийслэл Гэгэн хотыг бүслэн авсан нь Солонгос вангийн ордныхоныг ихэд сандаргаж, тэдэнд монголчуудтай эвсэн найрамдахаас өөр сонголтгүй болгов. Солонгосын ван элчээ Салидай жанжин руу илгээж, 1225 онд Их Монгол улсын элчийг солонгосууд биш, зүрчид нар алсаныг сайтар ойлгуулжээ. Монголын тал Солонгосын талын тавьсан саналыг хүлээн зөвшөөрч цэргээ татахаар шийджээ. Цэргээ татахынхаа өмнө эзэлсэн хот, суурин газарт даргач нэртэй 72 түшмэлээ суулган, нийслэл Гэгэн хотод төвийг нь байгуулж, түүгээр дамжуулан Солонгосын талаар баримтлах бодлого хэрэгжүүлэх, Солонгос улстай харилцах шинэ суваг тогтоох, улмаар өөрийн хяналтыг зохих хэмжээгээр бий болгох алхамыг Монголын тал хийжээ.<sup>12</sup>

Монгол, Солонгос хоёр улсын харилцаанд болсон дээр дурдсан үйл явдалд тухайн үед нийслэл Гэгэн хотод өндөр алба хашиж байсан Ли Кюү Бу биеэрээ оролцож, Их Монгол улс руу илгээсэн удаа дараагийн бичиг, захидлуудын төслийг боловсруулж байсан тухай түүхийн сурвалж бичигт тэмдэглэжээ.<sup>13</sup>

1232 оны зун Солонгос улсын вангийн илгээсэн их жанжин Жо Сук Чан,<sup>14</sup> тэргүүтэй элч нар Өгэдэй хаанд бараалхаж, Гуулин улс Их Монгол улсын хараат орон болсоноо албан ёсоор мэдэгджээ.<sup>15</sup> 1218-1219 оны хооронд Монгол, Солонгосын хамтарсан цэргийн хүч Солонгос улсад цөмрөн орсон хятан нарын дэгдээсэн самууныг дарах байлдааны ажиллагаанд Жо Сук Чан жанжны эцэг Жо Чун биеэр оролцож, солонгосын цэргийг тэргүүлж, монголын цэрэгтэй хамтран хятан нарт эзлэгдсэн Кандон хотыг чөлөөлөх тулалдаанд оролцон, монголын Хажин, Жала жанжин нартай маш дотно сайн харилцаатай байсан бөгөөд “Жала, Жо Чун хоёрын хооронд ах дүүгийн холбоо тогтоосон” хэмээн сурвалж бичигт тэмдэглэжээ.<sup>16</sup>

1232 онд Өгэдэй хаан, Жо Сук Чан тэргүүтэй Солонгос улсын элч нарыг хүлээн авч уулзахад Елюй Чуцай оролцож, тэдэнтэй дотно танилцан харилцаа холбоо тогтоосон тухай Елюй Чуцай “Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл” зохиолдоо “Гуулин улсын элч нарт зориулсан гурван бадаг бүхий шүлэг” хэмээх нэртэйгээр оруулжээ.<sup>17</sup> Энэ шүлгийн эхний хоёр бадагт хүчирхэг Их Монгол улсыг магтан дуулж сүүлчийн бадагт өөрийгөө танилцуулан бичжээ.<sup>18</sup>

Монгол, Солонгос хоёр улсын тохиролцооны дагуу монголын их цэрэг Солонгосоос гарсаны дараа Гуулин улсын ван, ордны их эрх мэдэл бүхий Чое Ю<sup>19</sup> тэргүүтэй түшмэдийн шахалтаар шадар албат, ураг төрлийнхнийгөө авч 1232 оны 6-р сард нийслэл Гэгэнээ орхин Канхва арал руу шилжин суурьшсан бөгөөд энэ нь цаашид Монгол улстай аль болохоор харилцахгүй байх, өөрсдийн аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилго агуулжээ.<sup>20</sup> Солонгосын ван Канхва арал руу дайжин суурьшсан болон монголын даргач нарыг заналхийлэх болсон явдлаас болж Өгэдэй хаан 1232 онд хоёр дахь удаагаа Солонгос улсад Салидай жанжнаар удирдуулсан цэргээ оруулан, Канхва арал руу элчээ илгээж вангийн ордонг эх газарт эгүүлэн байрлуулахыг шаарджээ. Гэвч энэ шаардлагыг Солонгосын ван хүлээж авахаас татгалзсанаар үл барам монголын цэргийн эсрэг ширүүн тулалдаж, Салидай жанжин тулалдаанд амь алдаж, монголын тал цэргээ буцаан татахад хүрчээ.

Монгол, Солонгос хоёр улс хоорондоо ийнхүү дайтахын зэрэгцээ хоёр улсын төрийн тэргүүн жуух бичиг, элч төлөөлөгч илгээх хэлбэрээр байдлыг тодруулах, санал солилцох, шаардлага тавих, тайлбар хийх, харилцааны хурцадмал байдлыг зохицуулах яриа хэлэлцээний арга замыг харилцаанд өргөн ашиглаж байв. Хоёр дахь

удаагаа цэргээ монголын тал татсаны дараа ч ийм яриа хэлэлцээ үргэлжилсээр иржээ. Тухайлбал, 1232 оны 10-р сард Ким Бу Жонг жанжин тэргүүтэй элч нар Их Монголын Өгэдэй хаанд бараалхав.<sup>21</sup> Энэ үед Монголын их хааны дэргэд Елюй Чуцай нөлөө бүхий хүн болохыг солонгосын тал нэгэнт мэддэг болсон учир шадар сайд Ли Кюү Бу солонгосын вангийн нэрийн өмнөөс Өгэдэй хаанд захидал илгээхийн хамт Елюй Чуцайд мөн захидал явуулжээ. Уг захидалд Елюй Чуцайг ихэд магтаж, түүнийг Жо Сук Чан тэргүүтэй өмнөх удаагийн Солонгос улсын элч нарыг халуун дотно сайн хүлээж авсанд гүн талархалаа илэрхийлэн, захидлын төгсгөлийн хэсэгт Солонгос улсын бодит хүнд байдлыг Өгэдэй хаанд зөв танилцуулан ойлгуулахыг хүсчээ.<sup>22</sup>

1238 оны 12-р сард Ким Бу Жонг жанжин тэргүүтэй элч нар Солонгосын вангийн захидалын хамт Их Монгол улсад ирж, Өгэдэй хаанд цэргээ гаргах хүсэлт тавьжээ.<sup>23</sup> Дээрх захидлыг Солонгосын вангаас эрх олгосны дагуу мөн л шадар сайд Ли Кюү Бу бичсэн бөгөөд тэрээр уг захидалын хамт Елюй Чуцайд бас захидал илгээжээ. Елюй Чуцайд илгээсэн энэхүү хоёр дахь захидалын зорилго нь 6 жилийн өмнө илгээсэн нэг дэх захидалтай нэгэн адил байлаа. Захидалд мөн л Солонгос, Монголын харилцааг хэвийн болгон сайжруулахыг солонгосын тал эрмэлзэж буйгаа аятай сайхан үгээр Өгэдэй хаанд зөв танилцуулан ойлгуулахыг Елюй Чуцайгаас хүсэв.<sup>24</sup> Елюй Чуцайд илгээсэн захидалын утга агуулгаас үзвэл, солонгосууд энэ удаа Өгэдэй хаанд их хэмжээний бэлэг сэлт захидалын хамт өргөн барьснаас гадна Елюй Чуцайд ч бас нэлээд нүнжигтэй бэлэг өгчээ.<sup>25</sup>

Солонгосын төрд өндөр алба хашиж, Солонгос, монголын харилцааны асуудалд биеэрээ оролцож байсан шадар сайд Ли Кюү Бу-гийн Елюй Чуцайд илгээсэн хоёр захидлаас үзвэл, Солонгосын вангийн ордныхон Елюй Чуцайг ихэд хүндэтгэж, нөлөө бүхий хүн хэмээн үзэж байсан нь тухайн үед Елюй чуцай, Өгэдэй хааны дотны хүн, Их Монгол улсын Төв бичгийн яамны тэргүүн сайд болон хааны ордны хятад хэл дээрхи бичиг баримтыг гардан хариуцаж байсантай шууд холбоотой байв. Тухайн үед Солонгос улсын гадаад харилцааны холбогдол бүхий баримт бичгийг хятад хэл дээр үйлдэж байсан болохоор Солонгос, Монголын харилцааны холбогдолтой бүх бичиг баримт, Солонгосын вангийн удаа дараа илгээсэн захидлуудыг Елюй Чуцай орчуулан Өгэдэй хаанд өргөн барьж, танилцуулж, шаардлага

бүхий зөвлөгөө өгч байсан зэрэг явдал нь Монгол, Солонгос хоёр улсын харилцаанд Елюй Чуцай зохих хувь нэмэр оруулж байсныг харуулав.

### ТАЙЛБАР ЗҮҮЛТ:

1. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 229 дэх тал., Хятадын түүхийн их толь бичиг /Чжунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 297 дахь тал. Елюй Люгэ нь 1165-1220 оны хооронд амьдарч байсан. Тэрээр Алтан улсын хойд хязгаарын мянгатын ноён байсан.

2. Хань Жулинь. Юань улсын түүх /Юаньчао ши/, дээд дэвтэр, Бээжин, 1986, 123 дахь тал., Хятадын түүхийн их толь бичиг, Шанхай, 1986, 297 дахь тал.

3. Монголын түүх судлал, 2-р боть, Хөх хот, 1986, 15-20 дахь тал.

4. Гуулин улсын түүх /Корё са/, 103-р дэвтэр, Ким Чуй Рё-гийн шастир., Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, УБ, 1995, 56 дахь тал., Сайшаал. Чингис хааны товчоон, доод дэвтэр, Хөх хот, 1988, 733-734 дэх тал., Хань Жулинь. Юань улсын түүх /Юаньчао ши/, дээд дэвтэр, Бээжин, 1986, 123-124 дэх тал.

5. Гуулин улсын түүх /Корё са/, 103-р дэвтэр, Ким Чуй Рё-гийн шастир.

6. Mongolica, An international annual of Mongol studies, vol. 10(31), Ulaanbaatar, 2000, p. 59.

7. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, УБ, 1995, 61 дэх тал.

8. Бичээч буюу эртний хэллэгээр битэгчи хэмээх нь бидний одоогийн ойлголтоор зөвхөн бичээч буюу бичиг хэргийн эрхлэгч төдий бус, харин Их Монгол улсын засаг захиргааны томоохон албан тушаалын нэр байжээ. Бичээч нарын ахлагчийг их бичээч хэмээдэг байсан бөгөөд хэрэг дээрээ төрийн сайдын албан тушаалтай тэнцэхээр байжээ.

9. Советский энциклопедический словарь, Москва, 1985, стр. 629., Үгсийн далай /Цыхай/, Бээжин, 2000, 2398 дахь тал. Солонгос бичиг үсэг анх 15-р зууны үед зохиогдсон бөгөөд 21 гийгүүлэгч, 19 эгшиг нийт 40 үсэгтэй. Солонгос бичиг үсэг зохиогдохоос өмнө хятад бичиг үсэг хэрэглэж байсан.

10. Гуулин улсын түүх /Корё са/, 102-р дэвтэр, Ли Кюү Бу-гийн шастир. Ли Кюү Бу нь 1168-1241 оны хооронд амьдарч байсан. 1190

оноос эхлэн Гуулин улсын төрд алба хашиж, Гуулин улсын вангийн зөвлөх, шадар сайд байсан.

11. Ли Кюү Бу. Зүүн улсын сайд Ли-гийн зохиолын эмхэтгэл /Дун гүк Ли сан гүк жиб/, 28-р боть.

12. Ч. Далай. Түүвэр зохиол, 1-р боть /Монголын түүх судлалын өгүүллүүд/, УБ., 2000, 205 дахь тал., Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, УБ, 1995, 61 дэх тал.

13. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, УБ, 1995, 61 дэх тал.

14. Гуулин улсын түүх, 130-р дэвтэр, Жо Сук Чаны шастир. Жо Сук Чан жанжин, Их Монгол улстай дайтаж болохгүй гэсэн үзлийг хатуу баримталсан.

15. Юань улсын судар, 208-р дэвтэр.

16. Мөн тэнд

17. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанжан цзюйши вэньци/, 7-р дэвтэр.

18. Мөн тэнд

19. Гуулин улсын түүх, 129-р дэвтэр. Чое Ю нь Чое Чун Хон /1196-1218/ жанжны хөвгүүн бөгөөд тухайн үед Солонгосын вангийн ордонд Чое овогт цэргийнхний ноёрхол тогтож байсан.

20. Хань Жулинь. Юан улсын түүх /Юаньчао ши/, доод дэвтэр, Бээжин, 1986, 407 дахь тал.

21. Гуулин улсын түүх, 23-р дэвтэр., Юан улсын судар, 208-р дэвтэр.

22. Ли Кюү Бу. Зүүн улсын сайд Ли-гийн зохиолын эмхэтгэл, 28-р боть.

23. Гуулин улсын түүх, 24-р дэвтэр., Юан улсын судар, 208-р дэвтэр., Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, УБ, 1995, 63 дахь тал.

24. Ли Кюү Бу. Зүүн улсын сайд Ли-гийн зохиолын эмхэтгэл, 28-р боть.

25. Мөн тэнд